

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ УРИЛГА

Он, сар, өдөр: 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр

Сонгон шалгаруулалтын нэр: **Хүнгүй агаарын хөлөг илрүүлэгч /дрон/ төхөөрөмж** нийлүүлэх, нийлүүлэгчийг сонгон шалгаруулалт.

Сонгон шалгаруулалтын дугаар: **AOD-2024/33**

Сонгон шалгаруулалтын босго үнэ /төгрөг/ - 771,381,000

“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК нь “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын **Хүнгүй агаарын хөлөг илрүүлэгч /дрон/ төхөөрөмж** нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтад эрх бүхий хараат бус хуулийн этгээдийг иж бүрэн битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

1. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн эрх бүхий оролцогч нь энэхүү урилгад заасан холбоосоор Захиалагчаас ажлын өдрүүдэд 08:00-16:00 цагийн хооронд нэмэлт мэдээлэл авч болно.
2. Сонирхсон оролцогч нь Захиалагчид бичгээр эсхүл цахим шуудангаар хүсэлт гаргаж, 55,000 (тавин таван мянга) төгрөгтэй /НӨАТ-орсон/ тэнцэх хураамжийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр төлснөөр Монгол хэл дээр бэлтгэгдсэн Сонгон шалгаруулалтын баримт бичгийг цаасаар эсхүл pdf өргөтгөлтэй файл хэлбэрээр худалдан авч болно. Төлбөрийг Захиалагчийн Голомт банкны 8125100892 тоот дансанд шилжүүлж /гүйлгээний утга дээр компанийн нэр, компанийн регистрийн дугаар бичнэ/ төлбөрийн баримтыг хүсэлтийн хамт хүргүүлнэ.

*\*Цахим шуудангаар илгээсэн хүсэлт ирээгүй, хугацаа хоцорч ирсэн, төлбөрийн баримт хаягдсан, баримт бичиг, тодруулга хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотойгоор Захиалагч ямар нэг хариуцлага хүлээхгүй.*

3. Сонгон шалгаруулалтад ирүүлэх саналаа **2024 оны 05 сарын 20-ны өдрийн 13:00 цагт** эсхүл түүнээс өмнө урилгад заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон саналыг хүлээн авахаас татгалзана. “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Захиргааны барилгын 2 давхар 201 тоотод **2024 оны 2024 оны 05 сарын 20-ны өдрийн 13:30 цагт** бүртгэх ба сонгон шалгаруулалтад оролцогчид, тэдгээрийн төлөөлөл, сонирхсон бусад этгээд оролцох эрхтэй.
4. Санал бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор сонгон шалгаруулалтад оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Захиалагч хариуцахгүй.
5. Ирүүлсэн саналуудыг нээх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгохдоо Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасныг дагаж мөрдөнө.

Хаяг: Монгол улс, Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ-Уул 41090, Тахилт толгой

Холбоо барих утас, цахим шуудан: 976-71287400, [procurement-1@nubia-llc.mn](mailto:procurement-1@nubia-llc.mn)

“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК